



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

“Болорзоос ББСБ” ХХК-ийн хаалттай  
өрийн бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”-ын 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Болорзоос ББСБ” ХХК-ийн гаргасан 12 сарын хугацаатай, нэг бүр нь 1000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 179,000 ширхэг, нийт 179,000,000 /нэг зуун далан есөн сая/ төгрөгийн үнийн дүн бүхий хаалттай өрийн бичгийг бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан журмаар хүлээсэн үүргээ чанд мөрдөж ажиллахыг “Болорзоос ББСБ” ХХК /Ш.Чинцэцэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-т даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000720